



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/852

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 40,000,000 (дөчин сая) төгрөгийн, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, 29,700,000 (хорин есөн сая долоон зуун мянга) төгрөгийн, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн балансад бүртгэлтэй, 1,062,053,990 (нэг тэрбум жаран хоёр сая тавин гурван мянга есөн зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 3 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг холбогдох байгууллагын удирдлагуудад нь зөвшөөрсүгэй.

2. Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгон соёлын ордон (Р.Мөнхсүрэн), Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Н.Оюунболд), Налайх дүүргийн 4, 6 дугаар хорооны "Суврага налайх" өрхийн эрүүл мэндийн төв (Б.Динара)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
 07 дугаар сарын 31 ны өдрийн  
 №/852 дугаар захирамжийн  
 хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиг алтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгуулага	Шилжүүлэн авах байгуулага
1	Дунд багтаамжийн автобус	Хьюндай старекс	57-41 УАЕ	KMJWA37 KADU54848 0	2013	40,000,000	17,500,000.14	22,499,999.86	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар	Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын төв
2	Бэсрэг автобус /микро/	УАЗ-220695-550 Фургон	36-18 УАА	ХТТ220695К 1211465	2019	29,700,000	17,325,000	12,375,000	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	"Суврага налайх" өрхийн эрүүл мэндийн төв
3	Гал унтраагч автомашин	Исүзү FVR23M	24-03 УНБ	JALFVR23M C7000002	2013	1,062,053,990	972,712,190.72	89,341,799.28	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн						1,131,753,990	1,007,537,190.86	124,216,799.14		